

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН  
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 20

Улаанбаатар хот

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, 11В ЕГСР системд бүртгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэнд хариу өгөх ажлыг зохион байгуулан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

Улаанбаатар хотын музейд 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, албан хаагчдаас нийт 17 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэн, албан хаагчдаас ирсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 21 цаг 50 минут байна.

Музейд 2022 оны эхний хагас жилд иргэдээс 1 өргөдөл, музейн албан хаагчдаас 16 өргөдөл ирснийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэв. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг болон захирлын тушаалыг программд оруулан хавсарган ажиллаж байна. /өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлан, хариу өгсөн хэлбэрийн тоон тайлан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан /байгууллагаар/, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан /албан хаагчаар/-г тус тус хавсаргав/

Музейд ирсэн иргэдтэй холбоотой өргөдөл, хүсэлт, гомдлын шийдвэрлэлт нь:

1. Хүсэлт гаргах тухай: Иргэн Б.Мэнд-Амар музейд хадгалагдаж байгаа Социализмын үед бүтээсэн плакатнаас сонгож гэрэл зургийг файл хэлбэрээр авахыг хүссэн тул түүний сонгосон плакатны гэрэл зургийг b.mend.amor@gmail.com имэйлээр хаягаар явуулж, хүсэлтийг шийдвэрлэв.

Музейд ирсэн албан хаагчидтай холбоотой өргөдөл, хүсэлт, гомдлын шийдвэрлэлт нь:

1. Ажлаас гарах тухай: Жижүүр П.Бямбажаргал нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан бөгөөд Музейн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж хөдөлмөрийн гэрээг цуцалсан.

2. Ээлжийн амралт авах тухай: Музейн боловсролын ажилтан Б.Даваасүрэн ээлжийн амралт авах хүсэлт гаргасан бөгөөд музейн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар 2022 оны 01 сарын 04-ний өдрөөс эхлэн ажлын 15 хоногоор ээлжийн амралт олгосон.

3. Ажилт орох тухай: Г.Цолмон нь музейн жижүүрийн албан тушаалд ажиллах хүсэлт өгч хүсэлт өгч нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдон тэнцсэнээр Г.Цолмонг музейн захирлын 2022 оны Б/04 дүгээр тушаалаар жижүүрээр томилон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулсан.

4.Жирэмсэний болон амаржсаны амралт авахыг хүссэн тухай: Музейн боловсролын ажилтан Б.Даваасүрэн нь жирэмсний болон амаржсан амралтаа авах хүсэлт гаргасан бөгөөд музейн захирлын 2022 оны Б/07 дугаар тушаалаар жирэмсний болон амаржсаны амралтыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс олгосон.

5.Ажилд орох тухай: Б.Төгсжаргал нь музейн боловсролын ажилтны албан тушаалд ажиллах хүсэлт өгч нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдон тэнцсэнээр Музейн захирлын 2022 оны 08 дугаар тушаалаар боловсролын ажилтан албан тушаалд томилогдон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажллас эхэлсэн.

6.Ажлаас чөлөөлөгдөх тухай: Дизайнер Д.Болд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан. Музейн захирлын 2022 оны Б/10 дугаар тушаалаар хөдөлмөрийн гэрээг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас чөлөөлөв.

7. Ажилд орох тухай: С.Эрдэнэбат нь музейн дизайнерайн албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан бөгөөд музейн захирлын 2022 оны Б/11 дүгээр тушаалаар 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн музейн дизайнерайн албан тушаалд томилон ажиллуулж эхэлсэн.

8. Ээлжийн амралт авах тухай: Музейн сан хөмрөгч П.Ариунаа нь эрүүл мэндийн шалтгааны улмаас ээлжийн амралтаа урагшлуулан авах хүсэлт гаргасан тул музейн захирлын 2022 оны Б/12 дугаар тушаалаар 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 18 хоногоор ээлжийн амралт олгосон.

9.Ажилд орох тухай: Д.Гантулга нь архив, албан хэргийн ажилтан албан тушаалд ажиллах хүсэлт өгч нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдон тэнцсэнээр музейн захирлын 2022 оны Б/13 дугаар тушаалаар музейн архив, бичиг хэргийн ажилтнаар 2022 оны 02 дугаар сарын 17-ноос эхлэн томилон, хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

10.Цалин хөлсний тухай: Музейн менежер Б.Нарангэрэл нь цалингийн шатлал шинэчлэх хүсэлт гаргасныг үндэслэн музейн захирлын 2022 оны Б/15 дугаар тушаалаар ТҮСУ-5-4 болгон шинэчлэн тогтоосон.

11.Цалин хөлсний тухай: Жижүүр Л.Жамбалдавга төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийн тухай хүсэлт гаргасан тул музейн захирлын 2022 оны Б/16 дугаар тушаалаар үндсэн цалингийн 10 хувиар тооцож нэмэгдлийг олгохоор шийдвэрлэв.

12.Цалин хөлсний тухай: Боловсролын ажилтан Б.Төгсжаргалаас Төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан. Музейн захирлын 2022 оны Б/22 дугаар тушаалаар Б.Төгсжаргалд төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 5 хувиар бодож, 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс олгохоор болов.

13.Цалин хөлсний тухай: Музейн жижүүр Ч.Хишигдэлгэр нь эхнэр амаржсан учраас цалинтай чөлөө хүссэн өргөдөл гаргасан тул музейн захирлын 2022 оны Б/23 дугаар тушаалаар 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 10 хоногийн цалинтай чөлөө өгч, 100000 төгрөгийн буцалтгүй тусламж олгов.

14.Ажлаас чөлөөлөгдөх тухай: Арга зүйч Э.Гэрэлмаа нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан. Арга зүйч Э.Гэрэлмаагийн өөрийн хүсэлтийг үндэслэн музейн захирлын 2022 оны Б/25 дугаар тушаалаар 2022 оны 05 дугаар


сарын 20-ны өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгов.

15. Нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай: Музейн боловсролын ажилтан Б.Даваасүрэн 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдөр амаржсан бөгөөд хүүхэд асрах чөлөө авах хүсэлтээ гаргасан. Музейн захирлын 2022 оны Б/24 дүгээр тушаалаар боловсролын ажилтан Б.Даваасүрэнд 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатай хүүхэд асрах чөлөөг олгов.


16. Ажлаас чөлөөлөгдөх тухай: Хүүхэд асрах чөлөө авсан нягтлан бодогч С.Азжаргал нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан бөгөөд музейн захирлын 2022 оны 06 дугаар сарын 02 оны өдрийн Б/27 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон.

### ХОЁР. МУЗЕЙН ЗАХИРЛЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

Тайлант хугацаанд иргэдтэй уулзалт хийгдээгүй болно.

ТАЙЛАН ХЯНАСАН:  


П.ДАВААСҮРЭН  
(Захирал)

ТАЙЛАН ГАРГАСАН:  


Ч.ӨСӨХЖАРГАЛ  
(Хүний нөөцийн ажилтан)  
Д.ГАНТУЛГА  
(Бичиг хэргийн ажилтан)